

ЦАХИМЖИЛТ, ИХ ӨГӨГДЛИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН
АХЛАХ ШИНЖЭЭЧ ЦЭВЭГМЭД ОВОГТОЙ СҮХБААТАРЫН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “Салбарын мэдээлэл технологийн үйл ажиллагааг хөгжүүлэх, нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх, цахим засаглалыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах, салбарын мэдээллийн аюулгүй байдлыг хангах” зорилтын хүрээнд”							
1.	Арга хэмжээ №1.1 Өрхийн мэдээллийн сан бий болгох үйл ажиллагаанд технийн дэмжлэг үзүүлэх.	Төрийн байгууллагуудаас шаардлагтай мэдээллийг авсан байна Мэдээллийн сан бий болсон байна Шаардлагатай нэмэлт хөгжүүлэлтүүд хийгдсэн байна	Хүнсний эрхийн бичиг хөтөлбөрт хамрагдах өрхийн суурь судалгаа хийгдсэн байгаа.	Өрхийн амьжиргааг тооцход шаардлагатай мэдээллийг төрийн байгууллагаудаас цуглуулсан байна.	Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/16, А/04 хамтарсан тушаалаар батлуулсан аргачлалын дагуу нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн – иргэнийг тодорхойлох амьжиргааны түвшний үнэлгээний оноог тогтоох зорилгоор 34,093 өрхийн 164,198 гишүүн-иргэний мэдээллийг ЭМДЕГ, ТЕГ, НДЕГ, ҮСХ зэрэг төрийн байгууллагуудын мэдээллийн сангаас шаардлагатай мэдээллийг ХҮР системээр дамжуулан авч өрхийн	2024.01.01 - 2024.12.10	95%

					амьжиргааг үнэлэх боломжийг бүрдүүлээд байна. Мэдээлэл солилцох шаардлагатай талбарыг тодорхойлох мэдээлэл хариуцагчтай уулзалт хийх, албан бичиг төлөвлөн явуулах, системийг хөгжүүлж буй зөвлөхүүдийн тайлантай танилцах шаардлагатай тохиолдолд чиглэл хүргүүлэх зэрэг дэмжлэг үзүүлж ажиллаа. Цаашид өрхийн мэдээллийн санд төрийн үйлчилгээний бусад системүүдээс амьжиргаа үнэлүүлэх хүсэлт гаргах, төрийн бусад байгууллагуудад хуульд заасан үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах мэдээлэл өгөх сервис хөгжүүлэхээр төлөвлөөд байна.		
2.	Арга хэмжээ №1.2 Төрөлжсөн асрамжийн үйлчилгээг үзүүлэгч байгууллага болон тус байгууллагуудаар үйлчлүүлсэн иргэдийн мэдээллийн санг бий болгох.	Мэдээллийн системийн шинжилгээ болон хөгжлүүлэлт хийсэн байна Сургалт зохион байгуулагдсан байна Системийг нэвтрүүлсэн байна. Мэдээллийн сан бүрдсэн байна.	-	Асрамж, халамжийн төвүүд болон тэдгээрээр үйлчлүүлсэн иргэдийн нэгдсэн мэдээллийн санг бий болгож хяналтыг сайжруулна.	Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр тус системийг хөгжүүлэхээр Куантум Партнерс ХХК шалгарсан бөгөөд системийн хөгжлүүлэлт хийгдэж https://asramj.ehalamj.mn/ хаяг дээр байршуулаад. Мөн асрамж халамжийн үйлчилгээ үзүүлэгч төрийн болон төрийн бус байгууллагуудыг хамарсан	2024.03.01 - 2024.10.10	85%

					сургалт болон системийн хөгжүүлэгчийн сургалтуудыг тус тус зохион байгуулаад байна. Цаашид системийг асрамжийн байгууллагуудын хэрэглэгчийн түвшинд нэвтрүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна		
3.	Арга хэмжээ №1.3 Хөдөлмөр эрхлэлтийн e-Job платформыг үйл ажиллагааг тогтворжуулах.	Системийн шаардлагатай сайжруулалтууд хийгдсэн байна Систем тогтвортой ажилласан байна.	Систем үйл ажиллагаанд нэвтэрсэн байгаа.	Системийн үйл ажилллагаа тогтворжсон байна.	Зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүллээ. - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаа. - eJob системийн өнөөгийн байдалд үнэлгээ хийлээ. - Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулж холбогдох албан тушаалтнуудад танилцууллаа. - Системийг сайжруулахтай холбоотой ажлын уулзалтуудыг ХХҮЕГ болон гүйцэтгэгч байгууллагуудтай хийлээ. 2024 оны 12 дугаар сарын байдлаар “Ejob” платформд Бүртгэлтэй ажлын байрны захиалга–96672, Ажил хайгчийн тоо–52760, Ажилд зуучлагдсан иргэдийн тоо–26935, Мобайл аппликэйшн	2024.01.01 - 2024.12.10	80%

					хэрэглэгчийн тоо-10950 болсон байна		
4	Арга хэмжээ №1.4 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын бүртгэлийн системийг бий болгох	Тест хийгдсэн байна Сургалт зохион байгуулагдсан байна Системийг эхний байдлаар нэвтрүүлсэн байна Мэдээллийн санг бүрдүүлж эхэлсэн байна.	Сисемийн эхний хөгжлүүлэлт хийгдсэн байгаа	Системийн тест хийгдсэн байна Эхний сургалтуудыг зохион байгуулагдсан байна	Зорилтын хүрээнд хөгжүүлэгч байгууллагаас программын эхний хувилбарыг гаргасантай холбогдуулан системийг Үндэсний дата төв дээр байршуулах ажлыг хамтран зохион байгуулав. Системийн хэрэглэгчид болох салбар комиссын төвийн зургаан дүүргийн нарийн бичгийн дарга нар, комиссын ажилтан зэрэг нийт давхардсан тоогоор 20 гаруй хүнийг хамруулсан санал авах болон эхний шатны 2 удаагийн сургалтыг 2024 оны 3, 5-р сард зохион байгуулаад байна. Сургалтын үеэр гарсан саналуудыг тусгах болон системийг ХУР системтэй холбох ажлын хүрээнд хөгжүүлэгч байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж дэмжлэг үзүүлж ажилласан.	2024.01.01 - 2024.12.10	80%
5	Арга хэмжээ №1.5 Монгол бичвэрийг авианд хөрвүүлэх программ хангамжийг хүлээн авах.	Програм хангамжийг хүлээн авсан байна Хэрэглээнд нэвтрүүлсэн байна.	Программ хангамжийн эхний хувилбарыг гаргасан.	Программ хангамжийг хүлээн авч хэрэглээнд нэвтрүүлсэн байна.	Зорилтын хүрээнд Монгол бичвэрийг авианд хөрвүүлэх ажлыг БолорСофт ХХК болон Чимэгэ ХХК-ын түншлэл гүйцэтгэсэн ба программ хангамжийн эхний хувилбарыг windows, linux, ios, android үйлдлийн системүүд дээр хөгжүүлэн программ хангамж	2024.01.01 - 2024.12.10	100%

					болон эх кодыг sonur.chimege.com, https://github.com/chimege/chimege-sonur-app хаяг дээр, мөн гар утасны аппликешнийг Appstore, Playstore дээр тус тус байршуулан олон нийтэд түгээж байна. Зарим хэрэглэгчийн зүгээс зохиогчийн эрхийн асуудалд маргаан үүсгэсэн ба холбогдох мэргэжлийн байгууллагууд болох ЦХИХХЯ, Оюуны өмчийн газраас зөвлөмжийг үндэслэн хэрэглэгч байгууллагын төлөөлөлтэй зөвшилцөх уулзалтуудыг хийж зөвшилцсөний үндсэн дээр системийг хүлээж аваад байна. Мөн Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 01/1251 тоот албан бичгээр тус системийг Цахим хөгжил, инновац харилцаа холбооны яаманд шилжүүлэн өгөх саналаа хүргүүлээд байна.		
6	Арга хэмжээ №1.6 Салбарын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх, удирдах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангаж журам боловсруулж, батлуулах	Журмын төслийг боловсруулсан байна Харьяа агентлаг байгууллагуудаас санал авч тусгасан байна Холбогдох албан тушаалтнуудаас санал авч тусгасан байна Журмыг батлуулсан байна	Журам	Журам батдлагдсан байна.	Салбарын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх, удирдах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангаж журмын төслийг боловсруулан харьяа агентлаг болон яамны холбогдох газруудаас санал авлаа. Харьяа агентлаг болон яамны газруудаас нийт 28 санал ирснийг журмын төсөлд тусгалаа. Журмыг Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын	2024.09.01 - 2024.12.10	100%

					2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/63 дугаар тушаалаар баталсан.		
7	Арга хэмжээ №1.7 Шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах, хүлээн авах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.	Тоног төхөөрөмжийн хэрэгцээг гаргах Техникийн тодорхойлолтыг боловсруулах, батлуулах Худалдан авах ажиллагаанд оролцох Тоног төхөөрөмжийг хүлээн авах	-	Шаардлагатай тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт батлагдсан байна. Тоног төхөөрөмжийг худалдан авсан байна.	Салбарын хэмжээнд шаардлагатай тоног төхөөрөмжийн саналыг харьяа агентлаг, байгууллагуудаас авч нэгтгэн холбогдох албан тушаалтнуудад танилцууллаа. Дээрх саналд үндсэн худалдан авах нийт 15 төрлийн тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг гаргав. Мөн тоног төхөөрөмжийг худалдан авах үнэлгээний хороо болон хүлээн авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж байна. 2024 оны 12 дугаар сарын байдлаар 3 төрлийн 227ш тоног төхөөрөмжийг худалдан аваад байна.	2024.01.01 - 2024.12.10	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Цахим засаглалын талаарх мэдлэгээ дээшлүүлэх.	Бусад орны туршлага судалсан байна Санал боловсруулсан байна	-	100%	Дэлхийн банкын дэмжлэгтэйгээр БНСУ-д зохион байгуулсан “Тогтвортой хөгжилд технологийн шийдлийг ашиглах нь” сэдэвт сургалтанд хамрагдаж БНСУ	1-12	100%

					болон Азийн бусад орнуудын цахим засаглалыг хөгжүүлхэд ашиглаж буй технологийн шийдлүүдтэй танилцлаа.		
--	--	--	--	--	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

ЦИӨБГ-ЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ
(Албан тушаал)

Ц.СҮХБААТАР  /
(Нэр, гарын үсэг)

2024.12.10
(Огноо)